

УДК 94+94(517)

ГАЛДАН БОШИГТ БА ОРОСЫН ЭЛЧ: УУЛЗАЛТ, ҮЛ ИТГЭЛЦЭЛ

Сампилдондов Чулуун

Түүхийн шинжлэх ухааны доктор, академич,
Ерөнхий нарийн бичгийн дарга, Олон улсын Монгол судлалын холбоо,
Ulaanbaatar, Mongolia
E-mail: samchuluun@gmail.com

Товч хураангуй

Монгол, Оросын XVII зууны харилцааны асуудлыг судлахад зайлшгүй нэгэн авч үзэхэд орхигдуулахгүй судлах нэгэн чухал судалгаа нь ойрадын Галдан бошигтын түүх юм. Түүний Зүүнгарын хаант улсыг захирах болсон үеэс эхлэн Галдан бошигтын харилцааны түүхийг авч үзэж болно. Ойрад, Оросын харилцааны түүхийг миний бие түүний эцэг Эрдэнэбаатар хунтайжийн харилцаагаар төлөөлүүлэн судалж гаргахыг оролдсон. Галдан бошигтын гадаад бодлого, үйл ажиллагааны асуудлыг хөндөхөд Зүүнгар ба Төв болон Дорнод Ази, Манж Чин улстай харилцсан харилцааг анхаарах хэрэгтэй. Харин БНХАУ-ын болон Оросын нэлээд эрдэмтэн судлаачид уг асуудлыг тусгайлан судлан авч үзжээ. Тиймээс би Галдан бошигтын харилцааны асуудлыг бага хөндсөн, бас нэлээд шинэ баримт эх хэрэглэгдэхүүн олсон учир Оростой хэрхэн харилцсан, түүний харилцааны онцлог, тухайн үеийн түүхэн нөхцөл байдал, элч нарын уулзалтын тэмдэглэл зэргийг голлон авч үзэхийг зорьлоо. Оросын сурвалжид түүний нэр анх үзэгдсэн нь 1665 оны үед хамаарна.

Түлхүүр үг

Түүх, Монгол, Орос, элч, Галдан бошигт.

UDC 94+94(517)

GALDAN BOSHIGT AND THE RUSSIAN AMBASSADOR: MEETING, MISTRUST

Sampildondov Chuluun

Dr. Sc. (History), **Academician**, Secretary-General
International Association for Mongol Studies,
Ulaanbaatar, Mongolia
E-mail: samchuluun@gmail.com

Annotation

The history of Galdan Boshigt of Oirat is one of the most important studies in Mongolian-Russian relations in the 17th century. The history of Galdan Boshigt's relationship can be traced back to his reign in the Dzungarian Empire. Galdan Boshigt's foreign policy and operations should focus on relations with Dzungaria, Central and East Asia, and the Manchu Dynasty. However, a number of Chinese and Russian scholars have studied the issue. Therefore, I did not touch on the issue of Galdan Boshigt's relations, and The author tried to focus on how he interacted with Russia, the specifics of his relations, the historical situation at that time.

Keywords

History, Mongolia, Russia, Ambassador, Galdan Boshigt.

О Р Ш И Л

Томскийн боярын хүү В. Бубенный Зүүнгарын Сэнгэ, Цөхүр зэрэг тайж нартай уулзсан тухай тэмдэглэлд “Кутухта лоба” [хутагт лам] гэсэн нэрээр тэмдэглэгджээ (РМО, 1996: 120). Энэ бол Ойрадын Равжам Зая Бандид Намхайжамц биш Галдан бошигт юм. Зая бандид 1662 онд тэнгэр болсон байв (Намсрай, 2015: 40). Тухайн үед Галдан шашны ном үзэж байсан хуврага байв. Намхайжамц Түвэдэд одсон байжээ (Раднаабадраа, 2009: 63-64). 1666 оны 8 сард Зүүнгарын тайж Сэнгэ, Цөхүр нартай уулзсан элч Томскийн боярын хүү В. Бубенный мэдүүлэг тайланд Галдан бошигтын тухай нэлээд дэлгэрэнгүй тэмдэглэгдсэн байна. Гэхдээ Галдан бошигтын бие дааж Оросуудтай харилцаж эхэлсэн нь 1667 оноос нэлээд үүрэгтэй оролцож эхэлжээ. Томскийн боярын хүү В. Былинийг ирэхэд тэрээр хэд хэдэн удаа уулзаж, өөрийн элч Дархан ламыг элчээр илгээхээр болж, бэлэг сэлт өгчээ (РМО, 1996: 189). Түүний тайлан мэдүүлэгт анх удаагаа “Галдан хутагт” [*Голдан кутухты*] хэмээх нэрээр тэмдэглэгджээ (РМО, 1996: 189). Энэхүү “хутугт” нэр нь шашны хутагтын цол биш хуучин ойрадуудын дээдэс хэрэглэж ирсэн “хутуг” цолны үргэлжлэл байж болох талтай.

ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА

Галдан бошигтын Оростой харилцсан харилцааны гол эх хэрэглэгдэхүүнийг би нэлээд олон жил хайж судалсны үр дүнд урьд өмнө судалгааны эргэлтэд ороогүй зарим тод үсгийн захидал, өмнө судлагдсан боловч дутуу, алдаа эндэгдэлтэй судлагдсан зүйлсийг дахиж үзэж зорилго тавьсан. Галдан бошигтод хамааралтай тод үсгийн, кирилл үсгийн бичгүүдийг шинээр судалгааны эргэлтэд оруулж байна. Мөн ОХУ-ын РГАДА-гаас гадна Польш улсын Краковын архивд В. Л. Ковтичийн хөмрөгт хадгалагдаж буй 10 гаруй захидал бичгүүд судалгааны эргэлтэд шинээр орж байна (Archiwum).

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Галдан бошигт энэ үед 1670-аад оны төгсгөлөөс үзэгдэхээ больсон нь тэрээр Түвэдийн газарт буцаж одсон бололтой. 1671 оны 6 сарын үед Тобольск хотын дарга И.Б. Репнинээс Сибирийн захиргаанд бичсэн захидалд

[Не дошел де Сенгина дального улуса в Тарском уезде в барабинских волостях сказывали им Сенгина улуса кочевные люди, что де тайшу их Сенгу в улусе брат ево родной Баатыр-тайша убил, а Сенгины де люди ево, Баатыря, и с сыном убили ж, а большой де ево Сенгин брат Чечен-тайша из улуса убежал к мугальскому Сайн-контайше с 30-ю человеки, а меньшей брат ево Галдам-кутухта после смерти бра[та] своево Сенги взял за себя жену ево Сенгину с людьми и повоевал Чокура-абаши-тайши сына ево Булат Манжи, [и] убежал в улус к тестю своему к Учюрте-тайше. Да и люди де ево Сенгины, кочевные и улусные калмыки, розбежались по розным кочевьям и улусам все без остатку] (РМО, 1996: 227-228).

“Сэнгийн улсад очоогүй Тарагийн Барабинскт явж байтал Сэнгийн улсын нүүдэлчид Сэнгэ тайшийг түүний төрсөн дүү Баатар тайш нь алж, харин Сэнгийн

хүмүүс Баатырыг хүүтэй нь хамт алж, харин том ах Цэцэн тайш нь улсаасаа гарч зугатаан монголын Сайн контайш дээр 30 хүний хамт очжээ. Харин бага дүү Галдан хутагт Сэнгэ ахыгаа нас барсны дараа Сэнгийн эхнэрийг өөрийнхөө эхнэр болгоод Цөхүр Убаши тайшийн Болд Манжисттай байлдаад, тэгээд хадам аав Очирт тайш дээр зугатан иржээ. Харин Сэнгийн нүүдэлчид ба халимагууд ийш тийшээ хэн ч үлдэхгүй таран нүүдэллэн одооцгоожээ”.

Галдан бошигтын хувьд энэ үеэс эхлэн өөрийн амьдралыг улс төрийн үйл хэрэгт бүрэн чиглүүлэх болжээ. Тэрээр өөрийн байр суурийг бэхжүүлэхийн тулд хамгийн эхэнд явуулсан нэг бодлого нь Сибирийн нутагт буй уугуул иргэдээс татвар авах, Тува, Хиргис нарыг Орост татвар төлөхгүй байхыг шаардаж эхэлжээ. Уг бодлогоос хамаарч түүний гадаад бодлого шууд Оростой уялдаж эхэлсэн байна. Татвар хураахтай холбоотой мэдээллийг Красноярск хотын дарга А. И. Сумароковийн Сибирийн захиргаанд бичсэн захидалдаа маш болгоомжтой сануулж дурдсан байна.

[И я, холоп твой, по твоему великого государя указу велел сказать Кутухтину яйзану, что преж сего те ясашные люди, канские и камасинские, ясаку калмыцкому Сенгину отцу ево и ему, Сенге, не плачивали, а ныне и ему, Кутухте, не пристойит с твоих великого государя ясашных людей ясак имать. И в том, государь, ясашном зборе от калмытцкого Кутухты и от киргиз и от тубинцов и впредь, государь, добра не чаеть, потому, государь, что они с твоих великого государя с ясашных людей ясак имать на калмыцково Кутухту и на себя, тубинцов. А ясашные, государь, люди быютчелом тебе, великому государю, чтоб им, калмытцким тайшам и тубинцам, ясаку с себя не платить и их бы оборонить, а всякое, государь, разоренье Красноярскому острогу всяким людем и татарам чинитца от киргиз и от тубинцов. А ныне, государь, киргизы и тубинцы тебе, великому государю, ясаку с себя не платят и кыштымом своим ясаку платить не велят же, а платят ясак они, киргизы и тубинцы, с себя и с кыштымов своих калмытцкому Кутухте, и во всем, государь, они радуют Кутухте] (РМО, 1996: 231).

“...Канск, Камасинскийн татвар төлөгч нар урьд нь Сенгийн эцэг, Сенга нарт татвар төлдөггүй байсан учраас одоо Кутухт та их хааны татвар төлөгч нараас татвар авах ёсгүй гэж хэлсэн. Эзэн хаан минь, Халимагийн Кутухт, тэдгээр киргиз, туба нарын Халимагийн Кутухат ба туба нарын өөрсөддөө зориулж татвар хураахтай холбоотой хэргээс яав ч сайн юм болохгүй. Харин татвар төлөгч нар халимаг тайш, туба нарт татвар төлмөөргүй байна, биднийг эзэн хаан хамгаалж өгнө үү, Красноярск цайз хотын олон янзын хүмүүс, татаруудад киргиз ба туба нараас болоод ямар нэгэн муу юм хүргэхгүй байна уу хэмээн их хаан таниас гуйж байна. Харин одоо эзэн хаан минь, киргиз, туба нар их хаан таньд өөрсдийн зүгээс татвар төлөхгүй, кыштымүүдээрээ ч татвар төлүүлэхгүй гэжээ. Харин киргиз, туба нар одоо кыштымүүдийнхээ хамтаар Кутухтад татвар төлж, Кутухтад талархаж явдаг болжээ”.

Галдан бошигтын хувьд Сибирийн давхар албат нараас татвар авахаас гадна өөрийн ах Сэнгийн эзэмшилд байсан Тува, Хиргис зэргээс татвар авах ажлаа үргэлжлүүлэх бодлого барьж байв. М.И.Гольманы дүгнэснээр Галдан бошигтын эхэн үеийн буюу 1670-1680-аад оны Оростой харилцаж байсан харилцаа нь ерөнхийдөө шууд дайсагнасан харилцаа байсан аж (Гольман, 2014: 178). Дотоодод ч маш хүнд

болж эхэлсэн. Хадам эцэг Хошуудын Очирт Сэцэний шахалт, эх нэгтэй эцэг өөр Зодов нарын хэрэг, Сибирийн уугуул иргэдийн асуудал зэргээс ихээхэн хамаарч байв. Оросын архивын материалд тэрээр ах Сэнгийг алагдсны дараа эргэн ирж Цэцэнг бүх үр хүүхдийн хамт хөнөөснөөс гадна ойр төрлийнхнөө хамт алсан гэж тэмдэглэсэн байна.

[Сенгу да тайшу убил в прошлом году брат ево Батур з братьями, а ныне де на ево место Сенгино брат ево Кутухта Кеген. И тот де Кутухта тово Батура убил, а с ним де побил племяни своево тайш и детей их человек с 40] (РМО, 1996: 230).

“Өнгөрсөн жил Сенга тайшийг түүний дүү Батур бусад дүү нарынх нь хамт алсан бөгөөд одоо түүний оронд Сенгийн ах Кутухта Кеген сууж байгаа. Тэгээд тэр Хутугта нь Батурыг алахдаа тайшийнхаа үеэл, хүүхдүүд гээд 40 хүнийг бас хамт алсан гэв”.

Уг баримтаас үзвэл Галдан бошигтын хувьд ах Сэнгийн үхэлд маш их хорсож харамсан байжээ. Тэрээр 27 настайдаа Ойрадын ханы ширээнд суусан юм. Галдан бошигт 20 нас хүртэлээ түвэдэд ном үзэж, номын цол хүртэж байжээ. Галдан Төв Азийн болон монголын дотоодын маш хүнд үед ханы ширээнд заларсан юм (Чимитдоржиев, 1987: 62). Гадаад бодлого тэргүүн эгнээнд анхаарч эхэлсэн. Дундад Ази, Орос, Манж Чин улстай харилцаагаа сэргээх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн ашиглах, гар урлалыг хөгжүүлэх, худалдаа эрхлэх явдлыг чухалчилж байсан. Ялангуяа Төв Ази дахь Дорнод Түрэгстантай эдийн засаг, стратегийн харилцааг тогтоох, Яркендын алтыг эзэмших явдал байв. Бас Хиргисүүд тэдний албатаас нэлээдийг хулгайлан авсан нь мөн л төвөг болж эхэлсэн байна. Тэднээс өөрийн албат иргэдээ буцаан авах, татвар авах зорилгоор Галдан бошигт дайны байдалд шилжиж байсан нь Оросуудын хувьд, ялангуяа Сибирийн шивээ гацааны хувьд ихээхэн болгоомжлоход хүргэжээ. Киргиз, ойратууд Кузнецк цайз хот руу дайрч орж ирэх аюултай байгаа тухай болон Зүүнгарын улсын байдлын тухай Томск хотын дарга Н.А.Вельяминовын Сибирийн захиргаанд бичсэн захидалд Хиргисийн Ераняк болон ойрадын Галдан бошигт нарыг Сибирийн хотуудыг үгүйрүүлэн сүйрүүлэхээр довтлон ирэх гэж буй хэмээн сандралдаж.

[И калмыцкие де тайши, 5 тайш, дали ему, Ереняку по сту человек воинских людей, и с теми де, государь, людьми Ереняк идет в свою землю. Да с ним же, Ереняком, идут 2 калмыцкие тайши, коих оставил Сенга на Мугальской земле, а с ними де, тайшами, воинских людей 4 тысячи. И те тайши с воинскими людьми и Ереняк с киргизы, и Талай с тубинды и с алтырцы, и кыштымы хотят приходить под Красноярской острог и на уезды с войною и ясашных людей воевать и разорять без остатку, а ис-под Красноярского, государь, острогу хотят итти войною на Енисейской острог и на уезды, и в Брацкую землю в Чеганы воевать] (РМО, 1996: 231-232).

“Тэгээд халимагийн 5 тайш Еренякт тус бүрдээ 100 цэрэг өгч, Ереняк тэр цэргүүдээ аваад өөрийн нутаг руугаа явуулжээ. Мөн Ереняк нартай хамт 2 халимаг тайш явж байгаа ба тэднийг Сенга Мугал газар орхисон ба тэдгээр тайшуудын цэрэг нь 4 мянга ажээ. Тэр хоёр тайж цэргүүдээ аван, мөн Ереняк киргизүүдийн хамт, Талай тубачууд ба алтыр, кыштымүүдийнхээ хамт Красноярск цайз хот ба тойрог дах татвар төлөгч нар, Брацкийн газар руу, Чеган руу нь дайрч, юу ч үгүй үгүйрүүлэхийг хүсч байгаа юм байна”

хэмээн мэдүүлээд Ереняк цаашаа Халимагийн бусад нутгаар явж, бас өөр хулгай хүмүүс болон киргиз хүмүүсийг хураан авч тэдгээр хүмүүстэйгээ Кузнецк

цайз хот, тойрог руу, Томск түүний тойрог руу ирж байлдана, татвар төлөгч нарыг юу ч үгүй хоосруулахыг хүсч байгаа юм байна. Энэ талаар Бүх Их, Бага, Цагаан Оросын хаан, их ван Алексей Михайлович та албат бид нартаа ямар тушаал өгөх вэ? гэж яаралттай захидал ирүүлжээ. Энэ цаг үеэс эхлэн ойрадын Галдан бошигтоос Оросууд нэлээд болгоомжлох болжээ. Красноярск руу цэргүүд ирүүлэхгүй бол болохгүй. Красноярск цайз хот бол захын хот бөгөөд халимаг, киргиз, туба хүмүүс Красноярскаас холгүй нүүдэллэн явж байгаагаас ихээхэн болгоомжилж айж байв. Галдан бошигтын цэрэг Сэнгийн үед байснаас нэлээд зүүн тийшлэн одоогийн Енисей, Хэм хэмчигийн сав нутаг, Тагнын уулсын хавиар нутаглах болсон нь Красноярск зэрэгт болгоомжлол төрүүлснээс гадна Сибирийн хотуудтай худалдааны харилцааг нэлээд өргөжүүлэх хүсэлтээ хэрэгжүүлэхийг зорьж байв.

[Да сентября в 6 день пришли от калмыцково Кегеня-контайши, что учинился на Сенгино место, купчины ево бухарцы Дейна с товарыщи, 12 человек, и, пришед, передо мною, холопом твоим, на съезде дворсказали и подали от Кегеня письмо, а в письме ево написано, что отпущены от нево бухарцы с торгами. Да они ж сказывали, что де контайша Кеген пришел с своей Калмыцкой земли на Мугальскую землю с калмыцкими людьми и стал де на Кемчюге-реке от Красноярсково в десяти днищах, и стоять де ему тут и зимовать, а преж сего он стоял на своих землях калмыцких, от Красноярсково острогу ходу до ево земли было 2 месяца] (РМО, 1996: 242).

“Мөн 9-р сарын 6-нд Халимагийн Сэнгийн оронд суусан Гэгээн хунтайж худалдаачин бухар Дейна ба түүний нөхөд 12 хүнийг явуулсан ба тэдгээр хүмүүс захиргаан дээр ирээд Гэгээний захидлыг өгсөн ба захидалд бараа бүхий бухаруудыг явууллаа гэжээ. Мөн тэд Гэгээн хунтайж өөрийн Халимаг газраасаа Монгол газар руу халимаг хүмүүсийн хамт ирсэн ба Кемчюг гол дээр Красноярскаас арван өдрийн зайд байгаа. Эндээ өвөлжинө. Өмнө нь тэд Красноярск цайз хотоос 2 сарын зайд байдаг өөрийн Халимагийн нутагтаа байсан гэж ярих”.

1671-1680 оны хооронд Зүүнгараас Орост нийтдээ одоо мэдэгдэж байгаагаар 6 элч, Оросоос 3 удаагийн элч Ойрадад ирсэн нь мэдэгдэж байна. Жишээлбэл, Тобольскийн боярын хүү Иван Карвацкий [1671], Петр Иевлев [1678], Яков Неприпасов [1680] нар ирсэн. Харамсалтай нь эхний хоёр элчийн тайлан мэдүүлэг харахан олноогүй байна.

1672 онд Галдан бошигт өөрийн албан ёсны бие даасан элч Дэвлет Шихаг Тобольскт илгээн цааш Москвад явуулахыг хүссэн захидал бэлгийн хамт явуулжээ. Тэрээр Тобольскт очоод өмнө явуулсан Галдан бошигтын элч ойрад Чептуга, Чадыр нарыг Москвад явуулахгүй байгаа учрыг тодруулахыг хүсэж, Галдан бошигт танай улсад муу зүйл хийхгүй өнөөг хүрснийг сануулж

[Будет де ево, Девлет Шиха, и прежних посланцов Зайсана и Чадыра к вам, великим государем, к Москве с листы и с подарки не отпустят, и впредь де вашим государевым послом, хто будет к тайше их посланы и которые приедут для торгу, быть задержаным] (РМО, 1996: 247).

“Хэрвээ Девлет Шиха намайг болон өмнө ирсэн Зайсан, Чадыр нарыг Москва руу их эзэн хаад руу захидал бэлгийн хамт явуулахгүй бол цаашидаа тайш руу нь явуулсан их хаадын элч гээд хэн ч байсан барьж саатуулах болно гэв”.

Оросын архиваас он цаг нь тодорхой бус боловч Галдан бошигт хаанаас илгээсэн элч Тобольскт хоригдсон тухай хэдэн тод үсгийн захидал олдоод байна. Түүнд бичсэн байдлыг үзвэл Галдан бошигтын элчийн захидал болох нь тодорхой:

[bošoytu qān arban kümün od geji ilgegsen bičiy tamγatai arban kümün irelei bi. yabun zabsar tu dörbön nökör mini ükübe. zuryān kümün tobol du irelei bi. toboliyin almoud dörbün kümün od getele namai arban kümün od geysen bičiy zarliyi ta бүгүдө дү медеүлсү geji qoyor nökörön a bči irelei bi. tendeki almoudiyin bičiy tu ese orobočigi ende yeke čayān qan yeke bayar zöbiyini medemče geji qoyor nökörön abči irelei bi. mini qoyor kümün-dü künesü ögüysēr yeke čayān qani šang dutaqu ügei. nere dү sayin ülü bayinu. qoyor nököriyin mini künesü yeke bayar qayirala] (РГАДА. Ф-214 [Сибирский приказ]. Оп. 3. Д. 544. Л. 418).

Элч нарыг саатуулсан, Москва явуулаагүй тухай Галдан бошигтоос дахин өөрийн элчийг Маметелипийг илгээж нарийн тодорхой тайлбарласан захидлын хамт явуулсан ба 1673 онд Ойрдын тайж нараас ирсэн элч нарын тухай болон зүүнгарын элч нарыг Тобольскт яагаад саатуулсан тухай Тобольск, Красноярск, Кузнецк хотын дарга нарын захидлууд дээр үндэслэн Сибирийн захиргаанаас заавраасаа Элчийн захиргаанд танилцуулсан захидлыг ирүүлжээ. Уг захидалд Галдан бошигтын элч нарыг хүлээж авахгүй Москва явуулахгүй шалтгаанаа маш тодорхой мэдүүлсэн байна.

[И того б Доян-тайши посла Кичю взять в съезжую избу и сказати ему, что их отпустить к Москве государева указу нет, а вперед о том, что тайшей их послов к Москве отпускать ли к великомугосударю, они, боярин и во[ево]ды Василей Борисович с товарищи, отпишут. А он бы, посол, к тайше своему ехал, а в Тобольску ему государева указу ожидати долго, потому что путь до Москвы дальней и проезд нужной, а государская де милость вперед к ним будет. А сказав, отпустить их ис Тобольска в калмытцкие улусы и проводить их велеть до коих мест таких послов преж сего проваживали. А за тайшины дары послати к нему государева жалованья — сукна или однорядку, примерясь к прежнему и смотря по их даром. А как они учнут вперед присылать в поминкахлошадь или две, и то б у них имати, а к ним против того посылати государева жалованья, сукна, чтоб им было нескорбно, а даром бы поминков у них не имати и насильств и в торгах неволи им никакие не чинить. А к Москве б калмытцких послов однолично не отпускать для того, что калмыцкие люди многие и воинские, и они б к Москве пути не узнавали, чтоб не учили также приходить, что и нагайские люди. А и прибыли в них нет некоторые и ссылке быть с ними не о чем: люди неученые и неграмотные, грамот к ним посылать не для чего, прочитати не знают и сами писать не умеют. А будет учнут приезжать в Тоболеск з базаром, и с ними велети торговать. А в те бы поры в городе однолично во всем было бережно, и крепостей им розсматривать не давать, и долго их в Тобольску не держать. А от которых тайшей послы в Тоболеск и в котором году, и о каком деле, и хто имяны придут, и с чем они отпущены будут, и что от них каких вестей объявитда, и с кем у них будет война, и о том ис Тобольска писати к великому государю] (РМО, 1996: 253-254).

“Тэгээд тэр Доян тайшийн элч Кичяг захиргаан дээр авчраад Москва руу явуулах эзэн хааны тушаал байхгүй, цаашидаа тайшийн элч нарыг Москва руу ирүүлэх талаар хотын дарга Василей Борисович нөхдийнхөө хамт захидал бичнэ. Харин элч та өөрийн тайш руугаа явах хэрэгтэй, учир нь Тобольскт эзэн хааны тушаалыг

удаан хүлээх хэрэгтэй болно. Учир нь Москва хүрэх зам хол бөгөөд тэр замыг туулах хэрэгтэй, гэтэл үүний өмнө эзэн хааны зөвшөөрөл ирэх ёстой гэж хэл. Ингээж хэлээд тэднийг Тобольскоос явуулах ба ингэхдээ ийм элч нарыг аль хүртэл гаргаж өгч байсан тэр ёсоороо гаргаж өгөөд тайшийн явуулсан бэлгийн хариуд эзэн хааны цалин буюу даавуу, урт цамц зэргийг хэмжээнд тохируулан, урьд өгч байсантайгаа харьцуулан өг. Тэгээд цаашидаа тэд нар бэлэг болгон нэг хоёр адуу авчраад байвал хүлээж аваад, эзэн хааны цалин хэмээн сайн даавуу өгөх хэрэгтэй. Тэдний бэлгийг зүгээр л авчихаж болохгүй, тэдэнд хүч хэрэглэж, худалдаа наймаанд нь дарамт үзүүлж болохгүй. Халимагууд олон бөгөөд дайчин хүмүүс болохоор Москва хүртэлх замыг тэдэнд мэдүүлэхгүйн тулд, тэдэнд нагай хүмүүст төрсөн шиг Москва орох санаа төрүүлэхгүйн тулд халимагийн элч нарыг Москва руу явуулах хэрэггүй. Тэднээс гарах ашиг гэж юу ч байхгүй тэдэнтэй ярилцаад байх ч хэрэггүй, эрдэм номгүй хүмүүс, тэдэнд захидал явуулаад ч хэрэггүй, уншиж ч мэдэхгүй, өөрсдөө бичиж ч чаддаггүй. Хэрвээ Тобольскт наймаа хийхээр ирвэл худалдаа хийх тушаал өг. Гэхдээ тэднийг худалдаа наймаа хийх үед бүх хүмүүс анхааралтай байж, цайзаа үзүүлэхгүй байж, Тобольскт удаан байлгах хэрэггүй. Ямар тайшийн элч, хэн гэдэг элч хэдэн онд ямар хэргээр ирснийг тэд юу авч яьсан, тэд ямар мэдээтэй ирсэн, тэд хэнтэй байлдаж байгаа тухай Тобольскоос захидал бичих хэрэгтэй”.

1674 онд Сибирийн захиргаанаас гаргасан нэгэн бичигт Галдан бошигтын элч нарыг юуны учир Москва явуулахгүй байгаа шалтгааныг тэд Красноярск, Енисей зэрэг шивээний татвар төлөгч нарыг Орост татвар төлүүлэхгүй байх, тэднийг өөртөө татах үйл ажиллагаа явуулж, тодорхой зорилгогүй элч нарыг ирүүлж байгааг дурджээ. Нэг талаасаа ийм шалтгаан байгаа боловч гол шалтгаан нь Оросуудын хувьд шинээр хүчтэй гарч ирж буй Галдан бошигтын элч нарыг аль болох Москвад очуулахгүй байх, тэдэнд зам зааж өгөхгүй байхыг чухалчилж Түшээт хаан Чахундорж, Өндөр гэгээн Жибзундамба нартай голлон харилцаж Байгал, Сэлэнгийн замыг нээж түүгээр Бээжин хүрэх, Манж Чин улстай харилцах явдлыг чухалд үзэж байв. Яг энэ үед болсон нэг жишээ нь Н. Г. Спафарийгийн хятад дахь айлчлал явах болсон тул Оросууд арга буюу Галдан бошигтын элч нарыг 1673 оны 8 сарын 1-нд Москвад хүлээн авчээ. Элч нар Галдан бошигтын 2 захидал авч очсон байна (Златкин, 1964: 244). Энэ элчийн мэдүүлгийг тодруулах баримт бараг алга. Харин энэ үед Москва Н.Г.Спафарийг эхлээд түүнийг ойрадын нутгаар хуучин Сэиткул Аблиний явсан замаар явуулахыг шийдэж 1675 онд Галдан бошигтод Алексей Михайлович хаанаас захидал хүртэл ирүүлж байсан ч тодорхой бус нөхцлөөр Енисей, Красноярск чиглэлээр явуулсан байдаг. Энэ нь Галдан бошигтоос болгоомжилсон явдал төдийгүй түүнтэй харилцах тодорхой ашиг байхгүй гэж дээр бичснээс мэдэгдэж байна.

Галдан бошигт улс орны дотоодын асуудал, Оросын элч нарт нь хандаж буй увайгүй байдлаас шалтгаалан хэдэн жил элчийн асуудлыг завсарлуулсны эцэст 1678 онд элч Сейбедин ходжа, Шар мэргэн тэргүүтнийг худалдаачдын хамт Тобольскт илгээжээ. Оросын тал энэ удаад түүний элчийг Москвад явахыг зөвшөөрч 1679 онд хүлээн авчээ. Ярилцлагынхаа төгсгөлд Сейбедин хожа Очирт Сэцэн хааны албат Галдан бошигтын мэдэлд шилжснийг мэдэгджээ. Галдан бошигтын элчийн тодруулга мэдүүлэгт өчснөөр

[А Галдан де тайша всегда желает царского величества с подданными служилыми и ясажными людьми жить в миру и в совете и своим улусным людем задоров и грабежей чинить с ясажными государевыми людьми не велит] (РМО, 1996: 324).

“Харин Галдан тайши бол эрхэм дээдэс эзэн хааны харъяат нар болон татвар төлөгч нартай дандаа эвтэй найртай байхыг эрхэмлэсээр ирсэн ба өөрийн хүмүүстээ эзэн хааны хүмүүс, татвар төлөгч нарыг дээрэмдэж, гомдоо гэсэн тушаал хэзээ ч өгдөггүй билээ гэв”.

Элчийг буцаж ирсний дараагаас эхлэн Галдан бошигтын Оростой харилцах харилцаанд нэлээд өөрчлөлт гарч эхний 10 жилд явуулсан харъяат хүмүүсээс алба татах, зарим үед хүч хэрэглэхээр заналхийлж байсан ч аажмаар маргаантай асуудлаарх байр сууриа зөөлрүүлэн, Орос улстай сайн хөршийн харилцаагаа бэхжүүлэхийг чухалчилах болжээ. Галдан бошигтын хувьд яг энэ үеэс эхлэн Манж Чин улстай элчин солилцох болжээ. Өөрөөр хэлбэл Галдангийн хувьд өмнө болон умард хөрштэйгээ эвтэй байх, гадаад бодлогын хувьд аюул занал бага байхыг анхаарч эхэлсэн байдаг.

Галдан бошигтоос 1678, 1679, 1683 онуудад Энх-Амгалан эзэн хаанд элч заран харилцахыг оролдож байжээ. 1680 оны 3-р сарын 24–9-р сарын 30. — Тобольскийн боярын хүү Я. Неприпасовын Зүүн гарын Галдан Бошигт хааныд элчээр очиход Галдан бошигт эзэнгүй байсан ба түүний эхнэр Ану хатан бусад тайж нарын хамт угтан авч уулзжээ. Оросын элч Я. Неприпасовын зүгээс зааврын дагуу буруутай хүмүүсийг эрж хайж байгаа эсэхийг, буруутай хүмүүст ямар тушаал өгсөн, их эзэн хаан ба Галдан тайжийн ойр зэргэлдээ амьдардаг хүмүүсийн эвтэй найртай байдлын тухай, татварын тухай, дураараа хүмүүсийг номхотгосон эсэх тухай, манай их эзэн хааны Галдан контайшид сайн ханддаг тухай, түүний элч Себедийн хаан хот Москвад хэрхэн амьдарч байсан тухай, их эзэн хааны элч Себеди хожад хүртээсэн хайр хишгийн тухай, гаалийн татварын тухай, бусад тайш нар болон үг сонсдоггүй хүмүүсийг их эзэн хааны өндөр дээд ивээл дор харъяат болгон оруулах тухай, Галдан тайшид өгсөн их эзэн хааны цалингийн тухай ярьсныг хатан болон бусад тайж нар сонсоод элчийн захидал болон бэлгийг хатан гүн хүндэтгэлтэй авч, өөрийн нэрийн өмнөөс элчин хариу явуулахаа мэдэгдсэн байна (РМО, 1996: 366-367).

Оросын архивын баримтад Галдан бошигтын хатан өөрийн нэрийн өмнөөс элч илгээсэн баримт хараахан мэдэгдэхгүй байна. Гэвч үүнээс хэдхэн сарын дараа 1680 оны 11-р сарын 11-нд *“Монгол болон ойратын элч нарыг Москва руу явуулахыг хориглосон тухай өмнө гаргасан тушаалыг батлах тухай”* Тобольск хотын дарга А. С. Шеинд Сибирийн захиргаанаас захидал ирүүлжээ. Гэвч үүнийг мэдсэн эсэх нь мэдэхгүй Галдан бошигтоос 1681 он гаруут өөрийн элчийг хэсэг худалдаачид, нэлээд их хэмжээний бараа таваарын хамт Сибирьт илгээж улмаар Москва явуулахыг хүссэн байна.

Галдан Бошигт хаан ба Номун хааны элч нарыг Тобольск, Туринскт саатуулсан тухай Тобольск хотын дарга А.С.Шеиний Сибирийн захиргаанд бичсэн захидалд

[А по скаске, государь, Гаврила Буткеева у Бушухту-ханова посланца Абдула Эрке-зайсана товаров 118 ширей с китайками, 2 шири да 2 ящика с камками да кореню-ревеню, что он, Абдул, объявил к тебе, великому государю, в дарех тайши своего, в двадцать одной шире и в мешках, а по весу, государь, того кореню-ревеню 120 пуд с четью с кожами и с мешками и с веревками, 22 человека кошеваров; у Намы-ханова Надыр Мергеня 7 ширей с китайками ж да 3 человека кошеваров.

И по твоему ж великого государя указу после допросу и переписки те товары у зайсана и у Надыра твоею великого государя тобольскою печатью я, холоп твой Алешка, велел запечатать. И сказали твой великого государя указ, что их, посланцов, велено отпустить ис Тобольска к тебе, великому государю, к Москве с товары их, опричь кореню-ревеню, а у иных у всяких чинов людей товаров никаких не имали и бухарцов к себе не принимали и своими людьми их не называли, едучи б дорогою в русских и в сибирских городех товаров своих не розвязывали и не распечатывали и никому не продавали] (РМО, 1996: 373).

“Таврийлийн хэлснээр Бошигт хааны элч Абдул Эрке зайсанд 118 хятад цайтай ширэн уут, 2 ширэн уут, 2 хайрцагтай араб торго, ревенийн үндэс байгаа ба энэ үндсийг их эзэн хаанд бэлэг болгож байгаа ба үндэс нь 21 ширэн уут ба хүүдийд байгаа ба нийт жин нь 120 пуд ба ширэн уут хүүдийний амыг нь боосон ба үүнээс гадна 22 кошевара хүн байв. Ному ханы элч Надыр мэргэнд 7 ширэн ууттай хятад цай, 3 кошевара хүн байв. Тэгээд их эзэн хаан таны тушаал ёсоор тэдгээр барааг бүртгэсний дараа зайсан болон Надырын барааг битүүмжлэх тушаал өгсөн. Тэгээд элч нарыг Тобольскоос их эзэн хаан тань руу Москва руу явуул гэсэн, ревенийн үндсээс бусдыг нь бараатай нь явуул, бусад хүмүүсийн барааг хамт авч явахгүй, бухаруудыг өөрийн хүн хэмээн авч явахгүй байх, явах замдаа Оросын Сибирийн хотуудад бараагаа задлахгүй, хүмүүст зарахгүй байх ёстой гэсэн таны тушаалын дагуу явуулсан” байна.

Галдан бошигт өөрийн элч Мэргэн хошуучыг Эрхүү хотод илгээж худалдаа эрхлэх, найрамдалт харилцаа тогтоох хүсэлтэй байгаагаа дуулгаж захидал, бэлгийг хүргүүлжээ. Оросын шивээний захирагчийн хувьд Манж Чин улсын тухай мэдээлэл, тэр дундаа Амурын сав нутагт тэдний цэрэг ирж байгаа эсэх тухай мэдээллийг тодруулжээ. Хариуд нь элч Мэргэн хошууч хэлэхдээ 1683 оны өвөл элч би Хятад улсад байсан, их эзэн хаадын их цэрэг Амур мөрөн рүү ирж байгаа гэдгийг үнэхээр сонссон. Мөн Амур мөрөн, Наунд амьдардаг хятад хүмүүс Их эзэн хаадын Москвагаас явуулсан цэргүүд тэднийг шахан хавчиж, оросуудаас болоод Амурт байх арга алга, Хятадын хаант улсаас хамгаалах нэмэлт цэрэг явуулна уу хэмээн захиа бичиж байсан. Тэгээд ийнхүү мэдэгдсэний дагуу буюу захидлын дагуу Хятадаас Амур мөрөн рүү 2000 цэрэг явуулсан. Өөр юм сонсоогүй. Хятадууд халимагууд бидэнтэй болон бухаруудтай бараг ярилцдаггүй, болгоомжилдог гэж үнэнээ өчсөн байна.

Гэвч Галдан дотоодын асуудал, халх Зүүнгарын харилцаа, Москватай хэл амаа ололцоогүй зэргээс болж 1680-1690 он хүртэл Оростой элчин харилцаа маш сул болсон байна. Оросуудын хувьд ч түүнээс нэлээд болгоомжилж байснаас болсон бизээ. Нөгөө талаар Галдан бошигтын халхтай өдүүлсэн дайны үед Оросууд эхэндээ Түшээт хаан Чахундорж нарыг буулгаж авахын тулд дэмжихээ байнга илэрхийлж байсан юм. Харин Ф.А.Головин Түшээт хаан Чахундорж нарыг өмнө зүгт шахагдан Сэлэнгэ, Үдийн сав нутаг аюулгүй байдал үүсэж эхэлсэнтэй холбоотой Галдан бошигтод туслах амлалтаасаа няцаж эхэлсэн. Түүний нэг том шалтгаан нь Нэрчүд Манж Чин улстай нэгэнтэй найрамдлын гэрээ байгуулсан нь Галдан бошигтод туслах бүх замыг хаасан байна.

ДҮГНЭЛТ

Тиймээс Галдан бошигтын Оростой харилцах харилцааг 1690-ээд оноос буюу Нэрчүгийн гэрээний дараахь үеийн харилцаа гэж тусгайлан авч үзэх нь чухалтай байгаа юм. Миний бие тодорхой тогтоосон он цагийн хүрээнд асуудлыг авч үзэж байгаа учир Галдан бошигт ба Оросын харилцааны 1690-ээд оноос хойших харилцааг өөрийн зохиолдоо дэлгэрүүлэн оруулах тул үүгээр таслан авч үзсэн болно.

Ном зүй

Archiwum Nauki PAN i PAU w Krakowie, W Kotwicz, j. 137.

Гольман, М. И. (2014). *Избранные статьи и доклады*. Редактор-составитель С. Чулуун; Институт истории Академии наук Монголии, Институт востоковедения РАН. Улан-Батор: Соёмбо принтинг.

Златкин, И.Я. (1964). *История Джунгарского ханства*. Москва.

Намсрай (2015). *Зүүнгар хаант улсын түүх*. Улаанбаатар.

Раднаабадраа (2009). Равжам Зая Бандидын тууж, сарны гэрэл хэмээх оршив. Латин галиг, үгийн цэс үйлдэж, кирилл бичгээр хөрвүүлэн, тайлбар бичсэн Х. Бямбажав. *Biblioteka Oiratica*. Т. XII. Улаанбаатар.

Российский государственный архив древних актов (РГАДА). Ф-214 [Сибирский приказ]. Оп. 3. Д. 544. Л. 418.

Русско-монгольские отношения (РМО). 1654-1685 (1996). Сборник документов. Составитель Г. И. Слесарчук. Ред. Н.Ф. Демидова. Москва: Восточная литература.

Чимитдоржиев, Ш. Б. (1987). *Россия и Монголия*. Москва: Восточная литература.

References

Archiwum Nauki PAN i PAU w Krakowie, W Kotwicz, j. 137

Golman, M.I. (2014). *Favorite articles and reports*. Editor-in-Chief S. Stone; Institute of History of the Mongolian Academy of Sciences, Institute of Oriental Studies of the Russian Academy of Sciences. Ulaanbaatar: Soyombo printing (in Russian).

Chimitdorzhiev, Sh.B. (1987). *Russia and Mongolia*. Moscow: Oriental literature (in Russian).

Namsray (2015). *History of the Dzungarian Empire*. Ulaanbaatar (in Mongolian).

Radnaabadraa (2009). Ravjam Zaya Bandid's novel «Moonlight». Kh. Бямбажав. *Biblioteka Oiratica*. Т. XII. Ulaanbaatar (in Mongolian).

Rossiiskij gosudarstvennyj arhiv drevnih aktov (RGADA). F-214 [Sibirskij prikaz]. Op. 3. D. 544. L. 418.

Russian-Mongolian relations. 1654–1685 (1996). Collection of documents. Compiler G. I. Slesarchuk. Ed. N. F. Demidova. Moscow: Oriental literature (in Russian).

Zlatkin, I. Ya. (1964). *History of the Dzungar Khanate*. Moscow (in Russian).